



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сэлбэ плаза ХХК-ийн “УБ сити” зочид буудлын 20/219, Кондитер Улаанбаатар ХХК-ын “Шинэ Алтай” зочид буудлын 20/238, Санжэм ХХК-ийн “УБ-Гранд” зочид буудлын 20/308, Ундецим Ундецим ХХК-ийн “Элеганс” зочид буудлын 20/297, Мөнх-Оюу ХХК-ийн “Анар” зочид буудлын

20/172, МЧБС ХХК-ийн “Соёл” зочид буудлын 20/172, Өндөр улаан трэвел ХХК-ийн “Редрок” амралтын газрын 20/353, Бодэнх ХХК-ийн “Очир” зочид буудлын 20/170, Юү эс эй энд би ХХК-ийн “Оргил” зочид буудлын 20/34, Хөх молор ХХК-ийн “Молор” дэн буудлын 21/188, Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын “Баянзүрх Шижир” амралтын газрын 20/211 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 07 сарын
01-ны өдрийн А/30 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

**ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1.	Сэлбэ плаза ХХК	2745461	УБ сити	СБД-ийн, 7-р хороо, Эрхүүгийн гудамж 11-р хороолол
2.	Кондитер Улаанбаатар ХХК	2626942	Шинэ Алтай	СХД-ийн, 18-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 28
3.	Санжэм ХХК	6389937	УБ-Гранд	СБД-ийн, 8-р хороо, Бага тойруу 14200, Сүхбаатарын гудамж 20/2
4.	Ундецим Ундецим ХХК	5429552	Элеганс	ЧД-ийн, 4-р хороо, Самбуугийн гудамж 16/3
5.	Мөнх-Оюу ХХК	5955009	Ти жи эс	БГД-ийн, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 18
6.	МЧБС ХХК	5054788	Соёл велнесс	ХУД-ийн 3-р хороо, Энгельсийн гудамж-4, Соёл төв
7.	Өндөр улаан трэвел ХХК	2782111	Редрок	НД-ийн, 6-р хороо, Горхи-Тэрэлж цогцолборт газрын Өндөр улааны зүүн өвөрт
8.	Бодэнх ХХК	5055733	Очир	БГД-ийн, 17-р хороо, Модны 2 үйлчилгээний төв
9.	Юу эс эй энд би ХХК	5091543	Оргил	ХУД-ийн, 11-р хороо, Дайчдын хөшөө 1-10

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 07 сарын
01-ны өдрийн А/30 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 07 дугаар сарын 01-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1.	Хөх молор ХХК	2693267	Молор	БЗД-ийн, 16-р хороо, Дандарбаатарын гудамж 46/1 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 07 сарын
01-ны өдрийн А/30 дугаар
тушаалын туравдугаар хавсралт

5284325 СБТ 4 8936 1115263562

**АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1.	ЭА Холдинг ХХК	6587399	Сэргээх /Рефрэш/	НД-ийн, 1-р хороо, Цонжин болдог
2.	Өглөгт Охин ХХК	2787407	Түмэн үндэс	НД-ийн 6-р хороо, Шижрээгийн ам
3.	Баянзүрх Шижир ОНӨААТҮГ	8113823	Баянзүрх Шижир	БЗД-ийн, 20-р хороо, Гацуурт тосгон, Шар хоолойн Шижиртийн ам

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР